- Хүүхдэд чиглэсэн халамжийн болон хүмүүнлэгийн аян, сургалт, урлаг спортын арга хэмжээг зохион байгуулах

-Хүүхдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэсэн орчин нөхцөл бүрдүүлэх -
Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлийг буруулах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн
үйл ажиллагааг зохион байгуулах

-Сумын хамтарсан багийн болон хүүхдийг аливаа хэлбэрийн хүчирхийллээс урьдчилан
сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлж, Хүүхдийн эрхийн асуудлаар олон нийтэд чиглэсэн
мэдээлэл, сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчин

- Төсвийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Нийгмийн даатгалын тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хууль;
- Ахмад настны тухай хууль;
- Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль;
- Бусад.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2022 онд харьяа орон нутаг дахь төсөвт байгууллагын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж нийт 33.5 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрснээс 42.6 хувь буюу 14.2 сая төгрөг нь өмч хөрөнгөтэй холбоотой зөрчил илэрсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтанширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Дорноговь аймгийн Санхүү төрийн сангаас боловсруулан гаргасан санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь , холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Алтанширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,786.9 сая төгрөгөөр буюу 53.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	235.20	192.26	-42.94
Авлага	185.37	121.73	-63.64
Бараа материал	292.51	91.43	-201.07
Нөөцийн бараа	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгө	4,528.73	2,049.53	-2,479.20
Нийт хөрөнгө	5,241.81	2,454.95	-2,786.86
Өр төлбөр	14.67	0.14	-14.53
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,227.14	2,454.81	-2,772.33
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,241.81	2,454.95	-2,786.86

Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад дансны эцсийн үлдэгдлүүдэд материаллаг өөрчлөлтүүд гарсан бөгөөд улсын төсвийн санхүүжилтийн байгууллага болох эрүүл мэндийн төв, сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагуудын төсөв, санхүүгийн тайлан харьяа Төсвийн ерөнхий захирагчдаа шилжиж байгаа нь материаллаг өөрчлөлтүүд гарахад нөлөөлсөн байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 192.3 сая төгрөг болж, өмнөх оноос 42.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	235.20	192.26	-42.94
Төгрөг	235.20	192.26	-42.94
Төрийн сангийн харилцах	234.38	192.26	-42.12
Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.82	0	-0.82
Дүн	235.20	192.26	-42.94

Эх сурвалж: Алтанширээ сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны өөрчлөлтөд: Орон нутгийн хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 13.5 сая төгрөгөөр, сум хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 27.4 сая төгрөгөөр, нөхөн сэргээлтийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 0.2 сая төгрөгөөр, нэмэлт дансны төвлөрүүлэлтийн үлдэгдэл болон ахмадын сангийн зарцуулагдаагүй мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1.8 сая төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн ба эцсийн үлдэгдэл 192.3 сая төгрөг нь төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 121.7 сая төгрөг болж, өмнөх оноос 63.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	0	0.05	0.05
Зээлийн хүүгийн авлага	3.58	0.65	-2.94
Байгууллагаас авах авлага	92.41	0.08	-92.33
Хувь хүмүүсээс авах авлага	0.19	0	-0.19
Зээлийн авлага	89.19	120.95	31.76
Дүн	185.37	121.73	-63.64

Эх сурвалж: Алтанширээ сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны өөрчлөлт нь Сум хөгжлийн сангийн авлагын үлдэгдэл 28.8 сая төгрөгөөр нэмэгдсэн, ЗДТГ-ын авлагын үлдэгдэл 2.0 сая төгрөгөөр, ЭМТ, сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагуудын 90.4 сая төгрөгийн авлагын үлдэгдэл тус тус буурсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Сум хөгжүүлэх сан –Тайлант оны зээлийн эргэн төлөлтийг бүртгэхдээ зээлийн хүүгийн авлагыг 0.01 сая төгрөгөөр илүү, үндсэн зээлийн авлагыг 0.01 сая төгрөгөөр дутуу тайлагнасан алдааг аудитын явцад залруулав.

Сум хөгжүүлэх сан –Тайлант онд ХХС-аас 80.0 сая төгрөгийн зээл олгосон бөгөөд зээлийн хүүгийн зардлыг нийт зээлийн хугацааны хүүгээр 6.3 сая төгрөгөөр буюу 4.7 сая төгрөгөөр илүү бүртгэсэн алдааг аудитын явцад залруулав.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 91.4 сая төгрөг болж, өмнөх оноос 201.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	117.20	1.06	-116.13
Тусгай зориулалттай материал	83.99	1.06	-82.93
Эм боох материал	33.21	0	-33.21
Дуусаагүй үйлдвэрлэл	0.10	0	-0.10
Бэлэн бүтээгдэхүүн	24.12	30.74	6.62
Хангамжийн материал	138.53	28.60	-109.93
Бичиг хэргийн материал	3.34	0.65	-2.69
Аж ахуйн материал	108.75	26.90	-81.85
Түлш, шатах тослох материал	0.53	0.90	0.38
Барилгын засварын материал	0	0	0.00
Хүнсний материал	12.60	0.14	-12.45
Бусад хангамжийн материал	13.32	0	-13.32
Мал амьтад	12.56	31.03	18.47
Дүн	292.51	91.43	-201.07

Эх сурвалж: Алтанширээ сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны өөрчлөлтөд: сумын ИТХ-ын үлдэгдэл 1.3 сая төгрөгөөр, ЗДТГ-ын үлдэгдэл 26.2 сая төгрөгөөр нэмэгдэж, Нөхөн сэргээлтийн сангийн бараа материалын үлдэгдэл 0.8 сая төгрөгөөр, ЭМТ, сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагуудын 227.8 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэл хасагдсан нь нөлөөлсөн байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 2,049.5 сая төгрөг болж, өмнөх оноос 2,479.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	4,415.01	1,972.48	-2,442.52
Барилга, байгууламж, орон сууц	3,029.33	889.04	-2,140.29
Авто-тээврийн хэрэгсэл	202.48	88.16	-114.32
Машин тоног төхөөрөмж(компьютер)	206.76	113.38	-93.37
Тавилга, аж ахуйн эд хогшил	85.99	18.97	-67.02
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	5.49	0	-5.49
Бусад үндсэн хөрөнгө	810.52	699.39	-111.13
Дуусаагүй барилга, байгууламж	47.87	163.54	115.67
Ном	26.57	0	-26.57
Биет бус хөрөнгө	113.73	77.05	-36.68
Программ хангамж	5.43	1.82	-3.61
Бусад биет бус хөрөнгө	108.30	75.23	-33.07
Дүн	4,528.73	2,049.53	-2,479.20

Эх сурвалж: Алтанширээ сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдлийн өөрчлөлтөд ЗДТГ-ын хөрөнгө 118.7 сая төгрөгөөр, ОНХС-ийн хөрөнгө 115.7 сая төгрөгөөр, ИТХ-ын хөрөнгө 8.8 сая төгрөгөөр нэмэгдэж, ЭМТ, сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагуудын 2722.4 сая төгрөгийн хөрөнгийн үлдэгдэл хасагдсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал – Тайлант онд актлагдсан хөрөнгийн элэгдлийг 0.01 сая төгрөгөөр илүү тооцсон алдааг аудитын явцад залруулав.

Сумын Засаг даргын тамгын газар - Сумын 2022 оны ИТХ-ын 47 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргад уламжлан шийдвэрлүүлэх 18.0 сая төгрөгийн автомашиныг үндсэн хөрөнгөөс зарлагадсан алдааг аудитын явцад залруулав.

Сумын Засаг даргын тамгын газар - Нийт 2.2 сая төгрөгийн 19 хөрөнгө хасах үлдэгдэлтэй санхүүгийн тайланд буруу илэрхийлэгдсэн алдааг аудитын явцад залруулав.

Сумын Засаг даргын тамгын газар - Хөрөнгөд бүртгэлтэй 5 дансны нийт 334.5 сая төгрөгийн хөрөнгө үлдэх өртөггүй байсан алдааг аудитын явцад залруулав.

3.4.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 0.14 сая төгрөг болж, өмнөх оноос 14.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Богино хугацаат өр төлбөр	14.67	0.14	-14.53
Ажилчидтай холбогдсон өглөг	1.57	0	-1.57
Бараа үйлчилгээний зардлын өглөг	9.48	0	-9.48
Байгууллагад төлөх өглөг	3.32	0.14	-3.18
Хувь хүмүүст төлөх өглөг	0.30	0	-0.30
Дүн	14.67	0.14	-14.53

Эх сурвалж: Алтанширээ сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдлийн өөрчлөлтөд: ЗДТГ-ын өглөг 0.5 сая төгрөгөөр, ЭМТ, сургууль, цэцэрлэгийн 12.9 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэл хасагдсан нь нөлөөлсөн байна.

3.4.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,454.8 сая төгрөг болж, өмнөх оноос 2,772.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,263.59	0.00	-2,263.59
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	0.00	1,115.26	1,115.26
Хуримтлагдсан үр дүн	998.91	671.38	-327.53
Өмнөх үеийн үр дүн	-17.15	3,365.44	3,382.59
Тайлант үеийн үр дүн	1,016.06	-2,694.06	-3,710.12
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,964.64	668.17	-1,296.47
Дүн	5,227.14	2,454.81	-2,772.33

Эх сурвалж: Алтанширээ сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал дансны үлдэгдлийн 2,263.6 сая төгрөгийн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансны үлдэгдлийн 2,296.5 сая төгрөгийн бууралтууд нь улсын төсөвт байгууллагуудын оны эхний үлдэгдлийн хасалт байна.

Хуримтлагдсан үр дүнгийн дансны үлдэгдэл 671.4 сая төгрөг болж 327.5 сая төгрөгөөр буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 554.6 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 6.2 сая төгрөг, нийт зарлагыг 560.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 65.2 сая төгрөгөөр бууруулж, 495.6 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Аймгийн ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 05/04 дугаар тогтоолд зааснаар Алтанширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 421.4 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсан ба үүнийг сумын ИТХ-ын 2021 оны 05/22 дугаар тогтоолоор нэмэгдүүлж, 528.3 сая төгрөгийг төвлөрүүлэхээр баталсан байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 07/42 дугаар тогтоолоор сумын татварын болон татварын бус орлогыг 99.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж 627.8 сая төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр 932.2 сая төгрөгийн татварын болон татварын бус орлогыг, бүрдүүлж, төлөвлөгөөг 304.4 сая төгрөгөөр давуулан 148.5 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт №10. Төвлөрүүлэх орлого

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэтгэлийн хувь
1	Үйл ажиллагааны орлого	8.66	11.42	-2.76	131.89%

Алтанширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2	Хадгаламжийн хүүгийн орлого	8.52	9.16	-0.64	107.57%
3	Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар	2.16	9.83	-7.68	455.98%
4	Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	9.26	2.14	7.12	23.12%
5	Галт зэвсгийн албан татвар	1.42	1.17	0.25	82.39%
6	Малын тоо толгойн албан татвар	76.90	74.10	2.80	96.36%
7	Улсын тэмдэгтийн хураамж	0.75	0.79	-0.04	105.71%
8	Газрын төлбөр	356.16	294.22	61.94	82.61%
9	Хог хаягдлын хураамж	5.66	5.29	0.37	93.43%
10	Түгээмэл тархацтай ашигт малтмал	86.06	86.83	-0.77	100.89%
11	Хүү торгуулийн орлого	4.00	4.39	-0.39	109.65%
12	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	0.94	23.97	-23.03	2557.60%
13	Ан амьтны нөөц ашигласан	-	317.24	-317.24	100.00%
14	Цалин хөлс түүнтэй адилтгах хөрөнгө	67.29	91.65	-24.36	136.20%
	НИЙТ	627.78	932.21	-304.43	148.49%

Эх сурвалж: Алтанширээ сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт 9 нэр төрлийн орлого 376.9 сая төгрөгөөр давж, 5 нэр төрлийн орлого 72.5 сая төгрөгөөр тасарсан байна.

Орлого давж биелсэн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Цалин хөлс түүнтэй адилтгах орлого төлөвлөсөн дүнгээс 24.4 сая төгрөгөөр давсан нь албан хаагчдын цалин нэмэгдсэнтэй холбоотой байна.
- Үйл ажиллагааны орлого төлөвлөсөн дүнгээс 2.8 сая төгрөгөөр давсан нь арьс шир, ноосны урамшуулал төвлөрүүлсэнтэй холбоотой байна.
- Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар 7.7 сая төгрөгөөр давсан нь төсөвт байгууллага бараа, ажил үйлчилгээ худалдан авсантай холбоотой байна.
- Хадгаламжийн хүүгийн орлого 0.6 сая төгрөгөөр давсан нь Төрийн банкны хадгаламжийн хүүгийн орлого 3 дугаар сараас сумын төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 0.8 сая төгрөгөөр давсан нь барилгын компаниудын үйл ажиллагаатай холбоотой байна.
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлого 23.0 сая төгрөгөөр давсан нь шинээр ногдуулсан болон уул уурхайн компаниудын татварыг барагдуулсантай холбоотой байна.
- Ан амьтны нөөц ашигласны төлбөр 31.9 сая төгрөгөөр тасарсан нь шонхор шувуу агнасны төлбөр орсонтой холбоотой байна.
- Хүү торгуулийн орлого 0.4 сая төгрөгөөр давсан нь татварын шалгалтаар ногдуулсан торгуулийг төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Орон нутгийн орлого дараах шалтгааны улмаас тасарсан байна. Үүнд:

- Галт зэвсгийн албан татварын орлого 0.3 сая төгрөгөөр тасарсан нь галт зэвсгийн бүртгэл, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой байна.
- Газрын төлбөр 61.9 сая төгрөгөөр тасарсан нь уул уурхайн компаниудын үйл ажиллагаа зогссонтой холбоотой байна.
- Хөрөнгө борлуулсны орлого 7.1 сая төгрөгөөр тасарсан нь үл хөдлөх хөрөнгийн борлуулалт, шилжилт хөдөлгөөн бага хийгдсэн, мөн суманд улсын бүртгэгч байхгүй байсантай холбоотой.

- Малын тоо толгойн албан татварын орлого 2.8 сая төгрөгөөр тасарсан нь суманд малын шүлхий, мялзан өвчинтэй гарсантай холбоотой мах, түүхий эд борлуулах хязгаартай байсан тул малчдын орлого буурснаас шалтгаалсан байна.
- Хог хаягдлын төлбөр 0.5 сая төгрөгөөр тасарсан нь ИТХ-аар төлбөрийн хэмжээг өөрчилсөнтэй холбоотой байна.

3.5.3 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр сумын ИТХ-ын 2021 оны 05/22 дугаар тогтоолоор 1,128.0 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 657.3 сая төгрөгийг урсгал зардалд, 470.7 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар баталжээ.

Нийт зардлын 74.2 сая төгрөгийг аймгаас авах татаас санхүүжилтээс, 523.8 сая төгрөгийг сумын татварын болон татварын бус орлогоос, 101.2 сая төгрөгийг оны эхний үлдэгдлээс, 390.9 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээс, 4.5 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос, нийт 1,128.0 сая төгрөгийг санхүүжүүлэхээр баталсан байна.

Тайлант онд төсөвт нэг удаа тодотгол хийсэн бөгөөд сумын ИТХ-ын 2022 оны 07/42 дугаар тогтоолоор 144.9 сая төгрөгөөр өсгөж 1,272.9 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголоор аймгаас авах татаас санхүүжилтийг 74.2 сая төгрөгөөр бууруулж, сумын татварын болон татварын бус орлогыг 134.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн нийт төсөв зарцуулах эрхийг 1,272.9 сая төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр сумын татварын болон татварын бус орлого 932.2 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт 390.9 сая төгрөг, үйл ажиллагааны орлого 61.0 сая төгрөг нийт 1,384.1 сая төгрөгийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,115.6 сая төгрөг буюу 87.6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагаа зардлын төсвийг 49.4 сая төгрөгөөр, ОНХС-ийн зардлыг 107.8 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 11. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэл т
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	534.82	485.45	49.37	90.8%
2	Баг, хорооны ҮАЗардал	52.11	52.10	0.01	100.0%
3	Мэдээлэл, сурталчилгааны зардал	0.26	0.254	0.01	97.7%
4	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	9.27	9.22	0.04	99.6%
5	Орон нутгийн нөөц хөрөнгө	25.00	25.00	0.00	100.0%
6	Хур хог хаягдал, орчны бохирдол	1.65	1.65	0.00	100.0%
7	Улсын их баяр наадам	5.00	5.00	0.00	100.0%
8	Багийн ИНХ-ын даргын урамшуулал	3.02	3.01	0.01	99.8%
9	Гэмт хэргээс урьдчилан сэргийл	7.00	6.99	0.01	99.8%
10	ОНХС – Бусад хөрөнгө оруулалт	634.74	526.89	107.85	83.0%
	Дүн	1,272.86	1,115.56	157.29	87.6%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 05/04 дүгээр тогтоолоор сумын Эрүүл мэндийн төв, Сургууль, Цэцэрлэг, Соёлын байгууллагуудын үйлчилгээ ашиглалтын зардлыг 304.5 сая төгрөгөөр, зардлын санхүүжилт 304.5 сая төгрөгийг аймгийн төсвөөс олгохоор тус тус баталсан байна.

Хүснэгт 12. Орон нутгийн өмчийн үйлчилгээ ашиглалтын зардлын санхүүжилтийн хуваарилалт, төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/

Алтанширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

д/д	Байгууллага	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Соёлын төв	41.28	40.91	0.37	99.10%
2	ЭМТөв	53.96	49.20	4.76	91.18%
3	Сургууль	161.04	159.72	1.32	99.18%
4	Цэцэрлэг	48.22	46.67	1.55	96.79%
	Дүн	304.50	296.50	8.00	97.37%

Гүйцэтгэлээр 323.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгон, цалингийн зардалд 39.8 сая, АОНДТШ-ийн зардалд 5.2 сая, тогтмол зардалд 254.5 сая, урсгал засварын зардалд 23.5 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 13. Орон нутгийн өмчийн үйлчилгээ ашиглалтын зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Зардлын төрөл	Төлөвлөгөө	/сая төгрөгөөр/	
			Гүйцэтгэл	Зөрүү
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	36.36	36.36	0.00
2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4.45	4.45	0.00
3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	240.19	237.00	3.19
4	Урсгал засварын зардал	23.50	18.69	4.81
	Нийт	304.50	296.50	8.00

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын илрүүлэлт:

Сумын Засаг даргын тамгын газар – Засаг даргын нөөц хөрөнгөөс хуваарилсан 6.0 сая төгрөгөөр, дээд шатны төсвийн хөрөнгөөс хуваарилсан хөрөнгийг 0.5 сая төгрөгөөр, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг 6.5 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй дүнгээр буруу орлогын дансанд илэрхийлсэн алдааг аудитын явцад залруулав.

Сумын Засаг даргын тамгын газар – 2 албан хаагчид нийт 0.2 сая төгрөгийн /НДШ, ХХОАТ суутгасан дүн/ ажил хавсран гүйцэтгэсэн нэмэгдлийг ажиллаагүй хоногуудад олгосон алдааг аудитын явцад залруулав.

Сумын Засаг даргын тамгын газар – Зочин төлөөлөгч хүлээн авах зардлын ангиллын нийт 2.6 сая төгрөгийн 19 гүйлгээг аж ахуйн бараа материал худалдан авах зардалд бүртгэсэн алдааг аудитын явцад залруулав.

Сумын Засаг даргын тамгын газар - Шилэн дансны системд нийт 13.1 сая төгрөгийн үнийн дүнтэй 2 зарлагын гүйлгээ болон худалдан авсан БАҮ-ий гүйлгээ, мөн 9.1 сая төгрөгийн орлогын гүйлгээг мэдээлээгүй зөрчилд албан шаардлага өгсөн.

Сумын Орон нутгийн хөгжлийн сан - Тайлант онд сумын орон нутгийн төсвөөс ОНХС-д гүйцэтгэлээр 121.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон. МТТАТатварыг 2.8 сая төгрөгөөр дутуу шилжүүлсэн зөрчилд зөвлөмж өгсөн.

Сумын Орон нутгийн хөгжлийн сан – Завсрын аудитаар "Малчдын сургалт сурталчилгаа, зөвлөгөөн" арга хэмжээг зохион байгуулахад нийт 4.5 сая төгрөг зарцуулснаас 3.0 мянган төгрөгийн 4 гүйлгээг цахим төлбөрийн баримтгүйгээр хийсэн зөрчилд зөвлөмж өгсөн.

Сумын Орон нутгийн хөгжлийн сан - Шилэн дансны системд нийт 126.4 сая төгрөгийн таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийн мэдээллийг, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 407.1 сая төгрөгийн 10 шийдвэрийн мэдээллийг байршуулаагүй зөрчилд албан шаардлага өгсөн.

3.5.4 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Орон нутгийн төсөвт байгууллагууд нь тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас 9.9 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 21.9 сая төгрөг, нийт 31.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс: хангамж, бараа материалын зардалд 5.1 сая төгрөг, норматив зардал 0.2 сая төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 2.5 сая төгрөг, томилолтын зардалд 2.1 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 20.3 сая төгрөг, хөрөнгийн зардалд 0.5 сая төгрөг, нийт 30.7 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 1.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Алтанширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, төсвийн үр ашигтай захиран зарцуулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллах талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг ахлах Б.Алтанзул гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер У.Оюунтүлхүүр, дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтанширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 01/108 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн 1.5 хувиар буюу 78.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Учир нь 2022 оноос улсын төсвийн санхүүжилтийн байгууллага болох эрүүл мэндийн төв, сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагуудын төсөв, санхүүгийн тайлан харьяа Төсвийн

ерөнхий захирагчдаа шилжиж байгаатай холбоотойгоор 2021 оны санхүүгийн тайлангаар материаллаг байдлын суурь үзүүлэлтийг сонгох боломжгүй гэж үзлээ.

Гүйцэтгэлээр материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн 2,454.9 сая төгрөгийн 1.5 хувь буюу 36.8 сая төгрөг, үүний 70 хувь болох 25.8 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш харьяа байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хэмнэлтийн горимуудыг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Сумын Орон нутгийн хөгжлийн сан - Шилэн дансны системд нийт 126.4 сая төгрөгийн таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийн мэдээллийг, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 407.1 сая төгрөгийн 10 шийдвэрийн мэдээллийг байршуулаагүй зөрчилд албан шаардлага өгсөн.

4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд 5 горим сорил хэрэгжүүлж төлөвлөгөөг батлуулсан.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	-	1	-	100%
Зөвлөмж	1	-	1	-	100%
Нийт дүн	2	-	2	-	100%

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татсан асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 3 тусгай сангийн нийт 5 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллага, сан түүврээр хамрагдсан байна.

Нөхөн сэргээлтийн тусгай дансны санхүүгийн тайланг аудит хийх байгууллагын тоонд оруулж, аудит хийх хуваарь батлуулаагүй ба ТТЗ-ийн санхүүгийн тайлангийн хугацаанд аудитад хамруулж, шалгасан болно.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд 1 байгууллагад “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1	0.02			1	0.02	1	0.02				
Засаг даргын тамгын газар	4	36.0			4	36.0	4	36.0				
Дүн	5	36.02			5	36.02	5	36.02				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо
Иргэдийн төлөөлөгчдийн хурал													
Засаг даргын тамгын газар	3	0.2	1	0.2	1	-	1	-					
Орон нутгийн хөгжлийн сан	2	5.8					2	5.8					
Дүн	5	6.0	1	0.2	1	-	3	5.8					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Сум хөгжүүлэх сан	1	-					1	-		
Дүн	1	-					1	-		